



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР

ЁС ЗҮЙ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Чак Конлон

MERIT төслийн зөвлөх

2022 оны 8-р сарын 16-ны өдөр

Сургалтын агуулга

Дараах чиглэлээр мэдлэг, ойлголтоо бататгана:

- Ёс зүй
- Яагаад ёс зүй гэж?
- Ёс зүйн нийтлэг зөрчил
- Ёс зүйн зөрчил, гомдол мэдүүлэх, хянан шийдвэрлэх
- Хууль эрх зүйн орчин



Хүмүүс хоорондын харилцааг зохицуулах ёс суртахууны хэм хэмжээ, стандарт юм.

Нийгмийн хэм хэмжээ

Хууль тогтоомж:

- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- ЗГ-ын 33-р тогтоол
- Ёс зүй сахилга хариуцлагын тухай хууль /төсөл/



ТА-ны үнэт зүйлс:

Бодлого:

- Ажлын эерэг орчин бүрдүүлэх
- Ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх
- Хүчирхийллийн эсрэг гм.

Шударга байдлыг эрхэмлэх, үр дүн, үр ашигтай ажиллах, Хариуцлагатай байх, Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, Харилцан хүндлэлтэй соёлтой харилцааг эрхэмлэх, Төлөвлөсөндөө хүрэх, Цагийн менежмент сайтай ажиллах, Бусдыг ойлгох, энэрэнгүй хандах

Шийдвэр гаргахад ёс зүйтэй холбоотой дараах зүйлсийг харгалзан үзэх:

- Хуульд нийцэж байна уу?
- Миний үйлдэл холбогдох бодлого, дүрэм журамтай нийцэж байна уу?
- Байгууллагын ү/а-нд сөргөөр нөлөөлөх шууд болон шууд бус үр дагавартай юу?
- Миний үйлдлийг гэр бүл, найз нөхөд, айл хөршүүд юу гэж үзэх вэ?
- Би энэ талаар нууцалсан нь дээр үү?
- Миний шийдвэр, үйлдэл өдөр тутмын сонины эхний нүүрэнд нийтлэгдвэл яах вэ?



Ёс зүйтэй харилцаа, хандлагыг
төлөвшүүлэх нь яагаад чухал вэ?

- Засгийн газар (Бүлэг 1)
- МХЕГ, НМХГ, АМХГ (Бүлэг 2)
- Албан хаагчид (Бүлэг 3)
- Иргэд олон нийт/харилцагч байгууллага (Бүлэг 4)



ЗГ-т үзүүлэх нөлөө

И

Ил тод байдлыг нэмэгдүүлнэ

О

Олон нийтийн итгэлийг нэмэгдүүлнэ

Ё

Ёс зүйгүй үйлдэлд илүү соргог хандана

Т

Төрийн албаны үнэт зүйлсийг бэхжүүлнэ

О

Олон улсын авилгын төсөөллийн индекс Монгол Улсын эрэмбийг бууруулна

Х

Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ



ОУ-ын авилгын төсөөллийн индекс

Дэлхий даяар судалгаанд хамрагдсан хүмүүсийн 69 хувь нь авлигыг асуудал гэж үзсэн байна.

Index 2020 Results table





Score	Country	Rank
36	El Salvador	104
35	Bosnia and Herzegovina	111
35	Panama	111
35	Mongolia	111
35	North Macedonia	111
34	Philippines	115
34	Moldova	115
33	Egypt	117

ASIA PACIFIC

MONGOLIA

Score	Rank	Score change
35/100	111/180	↓ -1 since 2012

[Read more](#)



МХЕГ-т үзүүлэх нөлөө

- Хууль тогтоомжийн хэрэгжилтийг дэмжинэ
- Байгууллагын нэр хүндэд эерэгээр нөлөөнө
- Ажлын орчинг илүү эерэг болгоно
- Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хандлага, чадавх бэхжинэ
- Үйл ажиллагааны эрсдлийг бууруулна
- Үр ашгийг нэмэгдүүлнэ
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартын дагуу эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг нэмэгдүүлнэ
- Ажлын байранд соёлтой, хүндэтгэлтэй харилцааг бэхжүүлнэ
- Хамтын ажиллагааг өргөжүүлнэ
- Хөдөлмөрийн зах зээлд нэр хүндтэй ажил олгогч байгууллага байх



Байгууллагын нэр хүнд, эрсдэл

Канад улсын хувийн хэвшлийн жишээ

- Дэлхий даяар 94,500 гаруй ажилтантай харилцаа холбоо, технологийн үндэстэн дамнасан корпораци **Nortel** нь Торонтогийн Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудын нийт үнэлгээний 1/3-ээс илүү хувийг дангаараа бүрдүүлдэг байв.
- Тус корпораци борлуулалтынхаа талаар худал мэдүүлэг хийсний улмаас 2009 онд дампуурлаа зарласан нь компанийн хувьцааны үнийг 79%-иар буурахад хүргэж, Канадын түүхэнд хамгийн өндөр дүнтэй дампуурал болжээ. Улмаар тэтгэврийн насныхан, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд их хэмжээгээр хохирол амсжээ.
- АНУ-ын Техас мужийн Хьюстон хотод байрладаг байсан эрчим хүчний компани **Enron** нягтлан бодох бүртгэлтэй холбоотой дуулианы улмаас татан буугдаж байв. 2001 онд компанийн нягтлан бодох бүртгэлийг хариуцан ажиллаж байсан дэлхийн хамгийн том нягтлан бодох бүртгэлийн групп компанийн нэг **Arthur Andersen** фирм мөн татан буугджээ. Учир нь Enron-д хийсэн аудитын үр дүнд **Arthur Andersen** фирм татан буугдсан. **Enron** санхүүгийн үйл ажиллагааныхаа талаар худал мэдүүлэг хийж, **Arthur Andersen** нь тухайн мэдүүлгийг баталгаажуулсан байжээ.

Албан хаагчдад үзүүлэх нөлөө

- А Ажил үүргээ гүйцэтгэхэд чиглэл, удирдлага болно
- А Ажлын орчин илүү эерэг болно
- А Албан хаагчдын үнэт зүйлстэй уялдана
- И Итгэлцлийг улам нэмэгдүүлнэ
- Х Хүндэтгэлтэй харилцаа, орчинг бүрдүүлнэ
- Х Хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ
- Х Хариуцлагыг нэмэгдүүлнэ
- Б Бодит үнэлэлт дүгнэлт өгөх чадвар нэмэгдэнэ



Иргэд, харилцагч байгууллагад үзүүлэх нөлөө

Н Найдвартай байдал, итгэлцлийг нэмэгдүүлнэ

Ү Үйл ажиллагааны үр ашиг, инновацлаг байдлыг нэмэгдүүлнэ

у Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ хэрэглэх, хүний болон нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд олон нийтийн итгэл, дэмжлэг улам нэмэгдэнэ



Рэдпат компанийн ёс зүйн зарчим

“Ажилтан бүрийн эзэмшвэл зохих **зан төлөвийг нарийн тодорхойлно. Байгууллагын нэр хүнд бүх ажиллагсдын зан төлөвийн цогц нийлбэрээр илрэх** тул биеэ зөв авч явах, зан төлөвийг тодорхойлсон баримт бичигтэй байх нь нэн чухал. Бид хамт олон, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, бусад ашиг сонирхлын бүлгүүдтэй **харилцахдаа өндөр ёс зүйтэй ажиллах үүрэг хүлээдэг.** Бид **шударгаар, өндөр ёс суртахуунтай ажилласнаар урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бүтээх боломж** бүрдэнэ.

Ёс зүйн дүрмээр аливаа нөхцөл байдлыг бүгдийг шийдэх боломжгүй ч, уг дүрэм нь бидний үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ёс суртахууны луужин юм.

Компанийн хувьд баримтлах үнэт зүйлсийг ёс зүйн дүрэмд тусгасан бөгөөд дүрмийн заалт, гол үзэл баримтлалыг мөрдөж ажиллана. **Манай компани нь дэлхийн хэмжээний компани бөгөөд байгууллагын соёлын үндэс нь шардргаар, ёс суртахуунтай ажиллах юм.**”

“Бид бүх харилцагч, талуудтай хүндэтгэлтэй, хариуцлагатай, ёс зүйтэй харилцааг эрхэмлэн ажилладаг тул тэд биднийг сонгосоор байдаг. Рэдпат нь 1962 оноос олон улсад үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тэр үеэс компанийн **нэр хүндийг тасралтгүй өсгөн,** байгууллагын үнэт зүйлсийн хүрээнд ёс зүй, ёс суртахууны стандартыг чанд баримталж ажиллаж ирсэн ажиллагсдадаа баярлалаа.”

Степ Голд ХХК-ний жишээ

Мэргэжлийн ёс зүйн стандарт: Ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж **бизнесийн нэр хүндийг** үргэлж хамгаалж, бүхий л үйл ажиллагааг нийтэд ил тод мэдээлж, **ёс зүйтэй, шударга, нэгдмэл байдлын** зарчмыг баримтлана. Ёс зүйн зарчмыг дагаж мөрдөөгүй аливаа үйлдлийг хүлээн зөвшөөрөхгүй ба энэ нь ёс зүйн ноцтой зөрчилд тооцогдоно.

Ялгаварлан гадуурхалт, дарамт, жишээ

POLL

Ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт



Бүх ажиллагсад аливаа хэлбэрийн дарамт шахалтаас ангид орчинд ажиллах эрхтэй.



Бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхол, нэр хүндэд ямагт хүндэтгэлтэй хандаж, аливаа хэлбэрийн айлган сүрдүүлэлт, ялгаварлан гадуурхалт, албадлагаас ангид эв нэгдэлтэй, хүндэтгэл бүхий ажлын орчинг бүрдүүлнэ.

RioTinto

Бид олон янзын соёл, нийгмийн бүлэг, үзэл бодлын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй ханддаг. Бид ажилтан тус бүрийн хувь нэмрийг үнэлэх, нэмэгдүүлэх зорилгоор шударга харилцааг эрхэмлэж, бусдын нэр хүндэд хүндэтгэлтэй ханддаг.

Байгууллагын эд хөрөнгийг ашиглах, жишээ



Байгууллагын эд хөрөнгийг ашиглах



Байгууллагын эд хөрөнгөд ариг гамтай хандаж, зөвхөн албан хэрэгцээнд ашиглана.



Байгууллагын эд хөрөнгийг хувийн ашиг сонирхол эсвэл зүй бус зорилгоор ашиглахаас бусад онцгой тохиолдолд хувийн хэрэгцээнд ашиглахыг зөвшөөрнө. Аливаа гутаан доромжлол, дарамт, хүчирхийллийн шинжтэй мэдээ, мэдээлэл, тухайлбал бэлгийн сэдэлтэй материал, хошигнол, хүсээгүй санал, үндэс угсаа, арьсны өнгөөр доромжилж дарамталсан мэдээлэл зэрэгт нэвтрэх, үзэх, илгээх, татаж авах, тараахыг хориглоно.



Компанийн техник тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглахгүй... Онцгой тохиолдолд ажил үүрэгт саад учруулахгүй байдлаар зохистой хэмжээнд ашиглахыг зөвшөөрнө. Энэхүү давуу эрхээ урвуулан ашиглах нь ёс зүйн зөрчилд тооцогдоно.



Байгууллагын өмч хөрөнгийг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах ба хууль бус зорилгоор ашиглахгүй. Захирал, албан тушаалтан, ажилтан нь компанийн өмч хөрөнгийг хувийн болон бусад этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлж ашиглахгүй.

Оюуны өмч – бүтээл, нээлт, худалдааны нууц ГМ., жишээ



Оюуны өмч

Redpath компанитай харилцах харилцаанд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ барааны тэмдэг, загвар, шинэ бүтээл, сайжруулалт, нээлт зэрэг аливаа хэлбэрийн оюуны өмч нь (протокол, журам, техникийн процесс, судалгааны аргазүй гм.) Redpath компанийн оюуны байна.

Redpath компанитай харилцах явцад олж авсан нууцлалын зэрэглэлтэй мэдээлэлд үндэслэн боловсруулсан оюуны өмчид хамаарах өмч хөрөнгө нь Redpath-ын оюуны өмчид хамаарна. Энэ тохиолдолд Redpath компанийн эзэмшлийг тодорхойлсон баримт бичигт гарын үсэг зурахыг шаардана.



...Аливаа гуравдагч этгээдийн худалдааны нууц, зохиогчийн эрхээр хамгаалагдсан мэдээлэл, нууц мэдээллийг зөвшөөрөлгүй ашиглах, хуулбарлах, тараахыг хориглох...



Ёс зүй сахилга хариуцлагын тухай хуулийн төсөл

10.3.5. Байгууллагад ажиллах үед олж авсан төрийн болон байгууллагын нууцад хамаарах мэдээллийг задруулахгүй байх.

Тайлагналт, мэдээллийн нууцлал, жишээ



Компанийн хувьцаа, үнэт цаастай холбоотой мэдээллийг үнэн зөв, цаг тухайд нь тайлагнах



Санхүүгийн бүх үйл ажиллагааг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн систем, бусад холбогдох дүрэм журмын дагуу бүрэн гүйцэт, үнэн бодит хөтлөнө. Зүй бус, хуурамч баримт бичиг бүрдүүлж мэдээлэх нь хууль бус үйлдэл юм



Бэлэг сэлт, үзвэр үйлчилгээ, жишээ





Аливаа үйлдлийн хариуг гэж ойлгогдохуйц бэлэг сэлт, үйлчилгээ, **ашигтай нөхцөл байдлыг** ажил хэргийн холбоотой албан тушаалтанд санал болгохыг хориглоно. Зайлшгүй тохиолдолд өгсөн бэлэг сэлт, үйлчилгээний **давтамжийг** сайтар харгалзах. Тогтмол олон удаагийн үйлдэл нийт дүнгээрээ байж болох хэмжээнээс давсан байх тохиолдол бий. Өмнө нь өгч заншсан бэлэг дурсгалын зүйлс тохиромжтой. Ажлын харилцаатай этгээдэд **250 ам.доллар** эсвэл хуульд заасан доод хэмжээнээс илүү үнэ бүхий бэлэг сэлт өгөхөөр бол хуулийн зөвлөх, удирдлага баталгаажуулна.



Бусдаас **шагнал, урамшуулал** эсвэл **тусгайлан үзсэн гэж ойлгогдохуйц** бэлэг сэлт, үйлчилгээ авахыг хориглоно. Тодорхой нөхцөлд, **үнэ багатай бэлэг сэлт солилцохыг зөвшөөрнө. Ажил хэргийн зоогийн** үеэр тухтайгаар мэдээлэл солилцох боломжтой ч зоог барих **хэр хэмжээ, давтамж** болон **нөхцөл** нь **авилга, улс төрийн шантааж, зохисгүй нөлөөлөл** үүсэх нөхцөлийг бүрэлдүүлэх эрсдэлтэй. Иймээс тухайн бэлэг сэлт нь шагнал, урамшуулал, онцгойлон үзсэн **утга агуулга** эсвэл **тэгж ойлгогдох** эсэхийг анхаарах нь чухал. Хэрэв тэгж ойлгогдохоор бол, компанийн дотоод журмын дагуу хориглоно. Бэлэг сэлт солилцох, аливаа ажил хэргийн аяллын замын зардлыг хариуцах зэрэгт SouthGobi Resource-ийн Бизнесийн ёс зүй, шударга ажиллах дүрмийг баримтална.


Ямар ч тохиолдолд аливаа үйлдэл тухайн улс орны хуулийн хүрээнд байна. Хэрэв аливаа бэлэг нь дүрэм журамд нийцсэн эсэхэд эргэлзэх тохиолдолд SouthGobi-ийн удирдлагын багтай зөвшилцөнө.

Зөрчил, гомдол хянан шийдвэрлэх

- Нөхцөл байдлыг сайтар судалж ойлгох;
- Зан төлөвөөс үүдэлтэй үүссэн асуудлыг тодорхойлох;
- Зөрчил үйлдсэн албан хаагчтай ярилцан үр дагаврыг таниулан, тухайн үйлдлийг зогсоохыг хүсэх;
- Үүссэн нөхцөл байдлын талаар шууд удирдлага, байгууллагын удирдлага эсвэл хүний нөөцийн мэргэжилтэнд мэдэгдэх;
- Ёс зүйн хороо гомдлыг хянаж шалгах;
- Мэдээллээр хангаж, хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд оролцох;
- Хянан шийдвэрлэх эрх бүхий албан хаагч шийдвэр гаргаж, авах арга хэмжээний талаар санал гаргах;
- Зохих арга хэмжээ, зөвлөмжийг хэрэгжүүлэх;
- Зөрчилтэй холбоотой арга хэмжээний нууцлалыг хадгалах.

Бусдыг үлгэрлэн манлайлах

Ёс зүйтэй зан
төлөв, хандлагатай
байх



Ач холбогдол багатай,
үл ойлголцол,
бухимдал үүсгэх
асуудлаас зайлсхийх

Мэдлэг ойлголтоо
тэлэх, бусдад
таниулах

Ёс зүйгүй зан
байдал, зөрчлийг
шууд мэдээлэх

Байгууллагын хариуцлага

- Баримт бичиг хөтлөлт, тайлагналт, мэдээллийн нууцлал, хамгаалалтад анхаарч, үнэн бодит байдалд анхаарах;
- Аливаа санал гомдлыг хянан, шийдвэрлэх (АХ, харилцагчид, иргэд олон нийтээс ирсэн);
- Зохих арга хэмжээ авах: соён гэгээрүүлэх, уучлалт гуйх, сахилгын гэх мэт;
- Хариу авах/өшөө авах нөхцөл бүрдүүлэхгүй байх;
- Шүгэл үлээгчийн нууцлалыг хадгалах;
- Зөрчил гомдол шийдвэрлэлтийн мэдээ тайланг жил тутам гаргах;
- Удирдлагын хариуцлага:
 - Үлгэр дуурайлал үзүүлэх
 - Ёс зүйтэй хандлагыг бэхжүүлэхэд эрсдэл үүрэх
 - АХ-дыг сургах, хөгжүүлэх
 - Ёс зүйтэй зан төлөв, хандлагыг урамшуулах
- Олон нийтийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар өндөр түвшний ёс зүйгээр манлайлж байгууллагыг сурталчлах.

Хууль эрх зүйн орчин



- Хууль, дүрэм журмын хэрэгжилт, ёс зүйт соёлыг хэвшүүлэх
- Үнэн зөв, хараат бус, найдвартай мэдээллээр хангах
- Хувийн мэдээллийн нууцлалыг хадгалах
- Байгууллагын өмч хөрөнгийг ариг гамтай хэрэглэх
- Байгууллагын өмч хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашиглахаас татгалзах
- Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх
- Иргэд, үйлчлүүлэгчдэд адил тэгш хандах
- Улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа нөлөөлөлд автахгүй байх
- Ёс зүйн зөрчилд арга хэмжээ авах
- Авилга, хээл хахууль авах, эрх мэдлээ урвуулан ашиглах, хууль зөрчихөөс сэргийлэх
- Ялгаварлан гадуурхалтыг хориглох
- Дарамт шахалтыг хориглох
- Гадаад оронд зорчих үед мөрийтэй тоглоом /казино/ тоглохыг хориглох
- Хууль бус үйлдэл, үүрэг даалгаврыг хориглох

Хууль эрх зүйн орчин_үргэлжлэл

1. Засгийн газрын 33-р тогтоол: Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм

- 25 хүртэлх албан хаагчтай байгууллагад 3-7 гишүүнтэй Ёс зүйн зөвлөлийн байгуулахаар тогтоосон.
- Ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой асуудлаар гомдол мэдээллийг хүлээн авах, шалгах, эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрхтэй.
- Ёс зүйн зөрчлийн тайланг жил бүрийн нэгдүгээр сард багтаан тайлагнана

2. Ёс зүй сахилга хариуцлагын тухай хууль /төсөл/

- Ёс зүйн стандарт хэм хэмжээг бий болгох
- Соён гэгээрүүлэх, сургалт хөгжлийн үйл ажиллагаа
- Гомдол, мэдээллийг хянан, шийдвэрлэх зохилцуулалт
- Төрийн байгууллага, олон нийтэд мэдээлэх, тайлагнах
- Сахилгын шаардлага
 - Хамтран ажиллагсад эсвэл олон нийтээс уучлалт гуйх
 - 6 сар хүртэлх хугацаагаар цалинг бууруулах эсвэл тушаал бууруулах
 - Албан тушаалаас чөлөөлөх



Хууль эрх зүйн орчин_үргэлжлэл

Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалтаас ангид байх
- Хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үгээр, биеэр, цахимаар болон бусад хэлбэрээр илэрхийлэхгүй байх
- Ажил олгогч ажилд орох гэж байгаа хүн болон ажилтнаас мөнгө, эд зүйл, иргэний үнэмлэх, гадаад паспорт, боловсролын баримт бичиг, мэргэжлийн үнэмлэх, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ зэрэг хувийн баримт бичгийн эх хувийг шаардан авч барьцаалахыг хориглох
- Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан гэж үзсэн ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргах
- Ажил олгогч хууль тогтоомжид нийцүүлэн ажилтанд хөдөлмөрийн сахилгын шийтгэл, эд хөрөнгийн хариуцлага ногдуулах
- Ажил олгогч хөдөлмөр эрхлэлттэй холбоотой гомдол, мэдээллийг хянан, шийдвэрлэх



- Канад Улсын төрийн албаны ёс зүйн үндсэн зарчим:
 - **Шударга, ил тод, хариуцлагатай, үр ашигтай, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх**
- Албан үүргээ гүйцэтгэх явцад болон аливаа албан харилцаанд шууд болон шууд бусаар бэлэг сэлт, үнэгүй зүйл, хөнгөлөлт дэмжлэг, үзвэр үйлчилгээ, зээл, мөнгөн дүн бүхий аливаа зүйлийг хүсэх, хүлээн авахыг хориглоно.
- **Хууль тогтоомжийг чанд мөрдөж, улс төрийн хувьд төвийг сахих уламжлалыг хадгалж ажиллах.**
- Төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр дүнтэй, үр ашигтай зарцуулахыг эрмэлзэх
- Төрийн албанд зорилгодоо хэрхэн хүрч байгаа нь ололт амжилтаас дутахгүй чухал байх ёстой.
- **Шат дараалсан сахилгын арга хэмжээ**
 - I. Сургалт, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх
 - II. Аман сануулга
 - III. Бичгэн сануулга
 - IV. Албан үүргээс түр түдгэлзүүлэх
 - V. Чөлөөлөх

ЗОРИЛТ

***МХЕГ НЬ АЖЛЫН ЭЕРЭГ ОРЧИН,
ЁС ЗҮЙТЭЙ ХАРИЛЦАА ХАНДЛАГААР
МАНЛАЙЛНА***



Монгол Улс:
Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс
баялгийн менежментийг сайжруулах (MERIT)

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж, Нэйшнл Таймс Ньюс Тауэр, 3-р давхар

Утас: 7610-5000